



“БАРИЛГЫН ХӨГЖЛИЙН ТӨВ” ТӨҮГ-ЫН 2023 ОНЫ “АВЛИГЫН ЭСРЭГ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ”-НИЙ ЖИЛИЙН ЭЦСИЙН ТАЙЛАН

Улаанбаатар хот
2023 он



“АВЛИГЫН ЭСРЭГ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ”-НИЙ 2023 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ТАЙЛАН

| Д/д | Зорилго | Хэрэгжүүлэх арга хэмжээ | Гүйцэтгэлийн үзүүлэлт | Хэрэгжүүлэх хугацаа | Биелэлт |
|-----|--|---|---|---------------------|---|
| 1 | <p>Авлигын эсрэг хууль тогтоомжийг иргэдэд сурталчлах, гэгээрүүлэх ажиллагааны хүртээмжийг нэмэгдүүлэх</p> <p>соён үйл</p> | <p>1.1. АТГ-аас бэлтгэсэн тв шторк, инфографик, видео график, нийтлэл, теле зохиомж, хөдөлгөөнт зураг, зурагт хуудас, цахим ном, гарын авлага зэргийг хэвлэл мэдээллийн хэрэгсэл, албан ёсны цахим хуудас болон нийгмийн сүлжээ, лед дэлгэц, сурталчилгааны самбарт байршуулах зэрэг бүхий л боломжит хэлбэрээр иргэд, олон нийтэд хүргэсэн байх;</p> | <p>Баримтжуулж, үр дүнг тооцож, тайлагнасан байх;</p> | <p>I-IV улиралд</p> | <p>Барилгын хөгжлийн төв” ТӨҮГ-ын 2023 оны авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан батлуулж, төвийн сайтад байршуулан мэдээллийг Авлигатай тэмцэх газарт хүргүүлсэн. Авлига, албан тушаалын гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, авлигын шалтгаан нөхцөлийг илрүүлэн тогтоох, арилгах, таслан зогсооход чиглэсэн “Авлигад үгүй гэж хэлье” фото постерыг пейж хуудсанд байршуулж шэйр хийсэн. Мөн пейж хуудасны профайл болон коверт “Авлигын эсрэг нэгдье” гэсэн зургаар сольж өөрчилөн аяны хугацаанд байршуулсан.</p> |

| | | | | | |
|--|--|--|--|---------------------|---|
| | | | | | <p>2023 оны “Барилгын мэдээлэл” эмхэтгэл 60 дахь жилдээ зохиогдон гарж байгаа бөгөөд энэхүү сэтгүүлийн хуудсанд оруулж өгсөн.</p> <p>“Барилгын хөгжлийн төв” ТӨҮГ-ын албан ёсны веб сайтын “Ил тод байдал” хэсгийн “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр” дэд хэсэг болон төвийн мэдээллийн самбарт байршуулан. Бэлтгэсэн мэдээллийг иргэд, олон нийтэд тогтмол хүргэн ажилласан.</p> |
| | | <p>1.2. АТГ-аас зохион байгуулсан аян, арга хэмжээг байгууллагын</p> | <p>Дэмжиж хамтран ажиллах, үр дүнг тайлагнасан байх;</p> | <p>I-IV улиралд</p> | <p>2023 оны авлига, албан тушаалын гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх жил</p> |

| | | | | | |
|--|--|---|--|---------------------|---|
| | | <p>онцлогт тохируулан зохион байгуулах;</p> | | | <p>болгосонтой холбоотойгоор авлигын шалтгаан нөхцөлийг илрүүлэн тогтоох, арилгах таслан зогсооход чиглэсэн “Авлигын эсрэг нэгдье” аянд нэгдэж фото постерыг бэлтгэн жилийн туршид төвийн пэйж болон цахим хуудасны коверт байршуулсан ба Нэгдсэн үндэсний байгууллагын Авлигын эсрэг конвенц батлагдсаны 20 жилийн ой тохиож байгаатай холбогдуулан “Дэлхийн нийтээрээ авлигын эсрэг нэгдье” энэхүү уриагаар дамжуулан авлигын эсрэг үйл хэрэгт хүн бүрийн оролцоог нэмэгдүүлэх замаар хүнд суртал, чирэгдлийг бууруулах авлигыг мэдээлж шүгэл үлээхийг уриалсан “Авлигын эсрэг нэгдье” аяныг байгууллагын хэмжээнд 2023 оны 3 дугаар сарын 29-ний өдөр зохион байгуулж аянд нэгдсэн талаар мэдээллийн самбарууд, төвийн албан ёсны фейсбүүк хуудсанд байршуулж ажилласан.</p> |
| | | <p>1.3. Авлигын эсрэг үйл ажиллагааг мэдээлэн сурталчлах “Шударга ёс, хөгжил дэвшилд 110” мэдээллийн самбар ажиллуулах;</p> | <p>- Мэдээллийг тогтмол шинэчлэх ажлыг хэвшүүлсэн байх; - Авлигатай тэмцэх газраас хүргүүлсэн мэдээллийг байршуулсан байх;</p> | <p>I-IV улиралд</p> | <p>“Шударга ёс, хөгжил дэвшилд 110 самбар”, байгууллагын албан ёсны вэб хуудсанд төлөвлөгөөг тус тус байршуулж, олон нийтэд ил тод, нээлттэй байдлаар хүргэсэн.</p> |

| | | | | | |
|---|--|--|--|-----------|---|
| | | | | | <p>“Авлигагүй нийгмийн төлөө”, “Хүмүүс авлигажсан тогтолцоог өөрчилж чадна гэдгээ ухамсарлах ёстой” гэх эдгээр ажиллуудын хүрээнд төвийн 2 давхарт авлигын эсрэг үйл ажиллагааг мэдээлэн сурталчлах “Шударга ёс, хөгжил дэвшилд 110” мэдээллийн самбарыг ажиллуулан, мэдээллийг тогтмол шинэчилж, хөтлөн явуулж байна.</p> |
| 2 | <p>Авлигын эсрэг сургалт зохион байгуулах, албан хаагчдыг АТГ-аас зохион байгуулах сургалтад хамруулах</p> | <p>2.1. Авлигын эсрэг сургалтын санал, захиалгыг төлөвлөгөөнд тусгуулахаар 01 дүгээр сарын 25-ны дотор АТГ-ын УССГХ-т хүргүүлсэн байх;</p> | <p>Сургалтад хамруулах санал, захиалга өгсөн байх;</p> | I улиралд | <p>Тус төв нь Авлигатай тэмцэх Үндэсний хөтөлбөр, Монгол Улсын Засгийн газраас баталсан авлигын индексийг бууруулах зорилтын хүрээнд байгууллагын 2023 оны “Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө”, 2023 оны 1 дүгээр сарын 10-ны өдөр батлан, хэрэгжүүлэн ажилласан. Төлөвлөгөөнд 6 зорилт, 12 арга хэмжээг төлөвлөн хэрэгжилтийг ханган ажилласан. Мөн “Шударга ёс, хөгжил дэвшилд 110 самбар”, байгууллагын албан ёсны вэб хуудсанд төлөвлөгөөг тус тус байршуулж, олон нийтэд ил тод, нээлттэй байдлаар хүргэсэн. Төвийн 2023 оны “Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө”-ний хэрэгжилтийн эхний хагас жилийн тайланг гаргаж төвийн цахим хуудсанд ил тод байдлыг ханган байршуулсан. Авлигатай</p> |

| | | | | |
|--|--|--|---------------|---|
| | | | | <p>газраас 2023.10.20-ны өдөр зохион байгуулсан “Төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлэх явцад ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх сургалт”-д тус төвийн “Сэлбэ сэргэлт төслийн нэгж”-ийн 8 ажилтныг хамруулсан.</p> <p>Авлигатай тэмцэх газарт хүсэлт гарган “Хасхом” бөглөх албан тушаалтны жагсаалт шинжлэгдсэнтэй холбоотой 2023.11.07-ны өдөр сургалт зохион байгуулж төвийн албан хаагчдыг хамруулсан. Тус сургалтад шинээр орсон ажилчдаа авлигын тухай мэдлэг дээшлүүлэх, авлигаас урьдчилан сэргийлэх түүнтэй тэмцэх арга барилт суралцуулах зорилгоор хамруулж нийт 30 албан хаагчдыг оролцуулсан. Мөн чанарын удирдлагын тогтолцооны стандарт ISO 9001:2015 нэвтрүүлэх үе шатны ажлын хүрээнд ISO37001 Авлигын эсрэг менежментийн тогтолцооны мэдлэг ойлголт олгох сургалтыг 2023 оны 10 дугаар сарын 20-ны өдөр зохион байгуулуулж төвийн 15 ажилтныг хамруулсан.</p> |
| | 2.2. АТГ-аас зохион байгуулах авлигын эсрэг анхан болон давтан сургалтад албан хаагчдыг хамруулсан байх; | Сургалтад хамрагдсан албан хаагчийн тоон мэдээлэл гарсан байх; | I-III улиралд | Авлигын эсрэг хуульд заасан авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиглэлээр сургалт сурталчилгаа явуулах |

| | | | | | |
|--|--|--|---|---------------------|--|
| | | | | | <p>“Сурагч багш” бэлтгэх анхан шатны сургалтад тус төвийн Захиргаа удирдлагын хэтсийн дарга Г.Түвшинжаргал хамрагдаж гэрчилгээ авсан.</p>  |
| | | <p>2.3. Авлигын эсрэг сургалт, сурталчилгаа, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг өөрсдийн нөөц бололцоонд тулгуурлан олон нийтэд хүргэх, шинэлэг арга хэлбэрээр зохион байгуулж, үр дүнг тооцон, тайлагнасан байх;</p> | <p>-Сургалт, соён гэгээрүүлэх ажлыг зохион байгуулсан байх; - Хамрагдсан тухай тоон мэдээлэл гарсан байх;</p> | <p>I-IV улиралд</p> | <p>“Шударга ёс, хөгжил дэвшилд 110 самбар”, байгууллагын албан ёсны вэб хуудсанд төлөвлөгөөг тус тус байршуулж, олон нийтэд ил тод, нээлттэй байдлаар хүргэсэн. Төвийн 2 давхарт авлигын эсрэг үйл ажиллагааг мэдээлэн</p> |

| | | | | | |
|---|--|---|---|---------------------|---|
| | | | | | сурталчлах “Шударга ёс, хөгжил дэвшилд 110” мэдээллийн самбарыг ажиллуулан, мэдээллийг тогтмол шинэчилж, хөтлөн явуулж байна. |
| 3 | <p>Авлигатай тэмцэх газраас бүрэн эрхийнхээ хүрээнд гаргасан шийдвэрийг биелүүлэх, хариуг хугацаанд нь мэдэгдэх, хүргүүлэх</p> | <p>3.1. АТГ-аас хүргүүлсэн зөвлөмж, мөрдөгчийн мэдэгдэл, зөрчил арилгуулах албан бичгийн хүрээнд холбогдох арга хэмжээг шуурхай зохион байгуулах;</p> | <p>Арга хэмжээг хэрэгжүүлэн, хариу мэдэгдэж, тайланг хүргүүлсэн байх;</p> | <p>I-IV улиралд</p> | <p>Авлигатай тэмцэх газраас 2023 оны 10 дугаар сарын 17-ны өдөр “Хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө оруулгын мэдүүлэг гаргах албан тушаалтны жагсаалтыг шинэчлэн батлах” тухай 05/16557 дугаар албан бичгийг тус төвд ирүүлсний дагуу төвийн 31 албан тушаалтнуудын жагсаалтыг шинэчлэн баталж 2023 оны 10 дугаар сарын 23-ны өдрийн 1/3104 дугаар албан бичгээр хүргүүлсэн. Мөн Авлигатай тэмцэх газрын Мөрдөн шалгах хэлтсээс шинжээч томилуулах, нотлох баримт гаргуулах албан бичгийг тус төвд ирүүлсэн бөгөөд 2023.10.13-ны өдрийн 06/16272 шинжээч томилуулах хүсэлт ирүүлсний дагуу, 2023.10.23-ны өдөр 1/3135 дугаартай албан бичгээр инженерүүдийн нэрсийг хүргүүлж, шаардсан материалыг нотлох баримтын шаардлага хангуулан хуулийн хугацаанд хүргүүлэн, хамтран ажиллаж байна.</p> <p>БХБЯ-наас ирүүлсэн 2023 оны 6 дугаар сарын 20-ны өдрийн</p> |

| | | | | | |
|---|--|--|--|--------------|--|
| | | | | | 8/2265 дугаартай албан бичгийн дагуу Авлигатай тэмцэх газрын зөвлөмжийн хэрэгжилтийг эрчимжүүлэх ажлын төлөвлөгөөнд тусгагдсан 5 арга хэмжээний хэрэгжилтийн тайланг Норм, нормативын хэлтэс, Барилга, барилгын материалын үйлдвэрлэлийн хэлтэс, Барилга байгууламжийн захиалагчийн хяналтын хэлтэс, Санхүү, төсөл хөтөлбөрийн хэлтсээс хүлээн авч нэгтгэн боловсруулж, удирдлагуудад танилцуулж албажуулан БХБЯ-ны Мэдээлэл, хяналт-шинжилгээ үнэлгээний газарт 2023 оны 9 дүгээр сарын 19-ний өдрийн 2/2638 дугаартай албан бичгээр 129 хуудас нотлох баримт бүхий хавсралтын хамт хүргүүлсэн. |
| 4 | Байгууллагын удирдлагын авлигатай тэмцэх хүсэл эрмэлзэл, санаачилга өрнүүлэх | 4.1. Авлигын эсрэг төрийн болон төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн байгууллагаас гаргасан санал, санаачилга, уриа, аянд нэгдсэн байдал; | Арга хэмжээг хэрэгжүүлж, үр дүнг тооцсон байдал; | I-IV улиралд | Барилгын салбарын бүх төрийн байгууллагууд, Авлигатай тэмцэх газартай хамтран 2023.7.15-ны өдөр ашиглаж буй мэдээллийн сангийн программаар танилцуулж, тулгамдаж буй асуудлаа хэлэлцэв. Үүнд: Программ хангамж гүйцэтгэх төсөв хэт өндөр, төрийн байгууллагад тогтвор суурьшилтай ажиллах мэдээлэл технологийн ажилтан ховор, тухайн орон тооны цалин бага |

| | | | | |
|--|--|--|--|--|
| | | | | байгаа нь тогтвор суурьшилтай ажиллахад нөлөөлдөг, нэг программист ажлаас гарахад тухайн хөгжүүлэгдсэн программ хангамжийн ажил бүрэн зогсдог. Төрийн байгууллагууд нь үйл ажиллагааны хувьд харилцан хамааралтай байдаг боловч мэдээллийн сангийн программ хангамжууд нь мэдээлэл солилцсон зохион байгуулалтгүй байдаг. Үүнээс шалтгаалан нэг төрлийн лавлагаа, мэдээллийг гаргаж авахад олон байгууллагаас тодруулж асуух шаардлага үүсэж цаг хугацаа их зарцуулж байна. Барилга, хот байгуулалтын яамны уулзалтад оролцсон байгууллагуудын мэдээллийн санг холбох аргачлалыг боловсруулах, төрийн байгууллагад ажиллаж буй мэдээлэл технологийн ажилтны цалинг нэмэх талаар төлөвлөгөө гаргахаар шийдвэрлэв. |
| | | 4.2. Төрийн байгууллага, хувийн хэвшлийн хооронд байгуулах аливаа гэрээ хэлэлцээрт авлигаас урьдчилан сэргийлэх асуудлыг тусгах талаар зохион байгуулалтын арга хэмжээ авсан байх; | Арга хэмжээг хэрэгжүүлж, үр дүнг тооцсон байдал; | I-IV улиралд Төвөөс иргэд, аж ахуй нэгж байгууллагатай байгуулах гэрээнд авлигаас урьдчилан сэргийлэх зохицуулалтыг тусган гэрээ, хэлэлцээрийг баталж хэвшсэн. Мөн боловсруулсан баримт бичгийн төсөлд “Санал өгөх хуудас”-нд шийдвэр гаргах үйл |

| | | | | | |
|---|---|---|---|--------------|--|
| | | | | | ажиллагаанд оролцоход ашиг сонирхлын зөрчил үүсэх эсэхийг тэмдэглэх хэсэг гарган, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг тогтмол авч ажиллаж байна. |
| 5 | Авлига, ашиг сонирхлын зөрчил шалтгаан нөхцөлийг арилгуулах арга хэмжээ авах үүсгэх | 5.1. Авлигын эрсдэл ба авилга гарах боломжийг бууруулах чиглэлээр холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх; /үйлчилгээг цахимжуулах, шат дамжлага бууруулах, ил тод байдлыг нэмэгдүүлэх, эрсдэлийн үнэлгээ хийлгэх зэрэг болно/ | Шинэ шийдэл, технологи нэвтрүүлэх замаар хүнд суртал чирэгдлийг багасгах үр дүнтэй арга хэмжээг зохион байгуулсан байх; | I-IV улиралд | Барилгын салбарын үйлчилгээг цахимжуулах, шат дамжлагыг бууруулах, ил тод байдлыг нэмэгдүүлэх ажлын хүрээнд “Барилгын салбарын нэгдсэн бүртгэл, мэдээллийн сан” цахим системийн хөгжүүлэлтийн ажил 100%-ийн гүйцэтгэлтэй хийгдсэн. Барилгын үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагааг цахимжуулж, 2021.07.01-ний өдрөөс эхлэн хүсэлтийг цахимаар хүлээн авч шийдвэрлэж байна. Тус системд Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа барилгын норм ба дүрэм, хууль эрх зүйн баримт бичгүүд цахим хэлбэрээр байршсан бөгөөд иргэн, хуулийн этгээд орон зай, цаг хугацаа харгалзахгүйгээр үнэ төлбөргүй татан авах, хэвлэх, үйл ажиллагаандаа ашиглах бүрэн боломжтой болсон. Мөн барилгын салбарын инженер техникийн ажилтнуудын бүртгэл мэдээллийн сан үүсгэж, |

| | | | | | |
|---|--|---|---|-----------------------------|---|
| | | | | | шинэчлэлт, баяжилт, хөтлөлтийг тухай бүр хийж байна. Барилгын салбарт үйл ажиллагаа явуулж байгаа хуулийн этгээд, инженер техникийн ажилтны мэдээллийг төрийн мэдээлэл солилцооны “ХУР” систем болон танилт нэвтрэлтийн нэгдсэн систем “ДАН”-аар дамжуулан УБЕГ, НДЕГ, БШУЯ-ны дээд боловсролын удирдлагын мэдээллийн сангаас татан авч байгаа тул мэдээллийн санд хуурамч мэдээлэл орох боломжгүй байдлаар хийгдсэн нь тус системийн давуу тал юм. |
| 6 | Байгууллагын үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг сайжруулах | <ul style="list-style-type: none"> • Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.4; • Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4; • Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.9-д заасан арга хэмжээг заасан хугацаанд албан ёсны цахим хуудсанд байршуулах, иргэд олон нийт үзэж, танилцах боломжоор хангах; | Хуулийн хэрэгжилтийг хангуулж, иргэдэд ойлгомжтой, хүртээмжтэй байдлаар хүргэхэд анхаарсан байх | Хуулийн хугацаанд тухай бүр | “Барилгын хөгжлийн төв” ТӨҮГ-ын албан ёсны веб сайтын “Ил тод байдал” хэсэгт байршуулсан “тендер, худалдан авалт” дэд хэсэгт байгууллагын 2023 оны худалдан авах үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудын урилгыг тухай бүр байршуулан ажиллаж байна. Мөн төвийн захирлын тушаалаар байгуулагдсан үнэлгээний хороод тендер шалгаруулах урилгыг цахим системд байршуулан тендер шалгаруулалтыг хуулийн хугацаанд гүйцэтгэн ажиллаж байна. Мөн Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-д заасан хугацаанд төсөв |

| | | | | | |
|--|--|--|--|--|---|
| | | | | | зарцуулалттай холбоотой мэдээллийг “Шилэн данс” цахим системд тогтмол нийтлэн, байгууллагын албан ёсны веб хуудасны “Ил тод байдал” хэсэгт байрших “төсөв, гүйцэтгэл” дэд хэсэгт шилэн дансны мэдээллийн сан руу шууд холбогдох https://shilendans.gov.mn/org/6544?group=0&year=2020 линк байршуулан, байгууллагын төсөв зарцуулалттай холбоотой мэдээ, тайланг иргэд, олон нийтэд хялбар хүргэх боломжийг бүрдүүлсэн. |
|--|--|--|--|--|---|

.....oOo.....